

## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.11.15

Сайншанд сум

д/д	Арга хэмжээ	Арга хэмжээний хэрэгжилт
0	1	2
<b>Хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр</b>		
1	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 35.1.4 дэх хэсэгт жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтны ажил албан тушаалыг хэвээр хадгалах, мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах ба МУ-ын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд ..., мөн жирэмсэн болон хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглоно” гэх заалтыг хэрэгжүүлж энэ төрлийн зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллах</p>	<p>Хэлтсийн хэмжээнд хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч байснаас мэдээлэл технологийн ажилтан П.Азжаргал, Сайншанд сумын иргэний улсын бүртгэгч Г.Нандин-Эрдэнэ нарын хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч, ажилдаа эргэн орох хүсэлт гаргасныг шийдвэрлэж, томилсон.</p>
2	<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2 дахь хэсэгт заасны дагуу ажил олгогч ажлын ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх</p>	<p>Тус хэлтэс нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, ажлын байран дахь бэлгийн дарамт, түүнээс ангид байх талаар богино хэмжээний кино, шторк үзэх, харилцан ярилцах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрхийн улсын байцаагч Б.Энхтуяаг урьж, хэлтсийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</p>
3	<p>Ажилтан, албан хаагчдын жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, гэгээрлийн ажлыг үе шаттай зохион байгуулах</p>	<p>Жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, ажлын байран дахь бэлгийн дарамт, түүнээс ангид байх талаар богино хэмжээний кино, шторк үзэх, харилцан ярилцах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн эрхийн улсын байцаагч Б.Энхтуяаг урьж, хэлтсийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</p>

4	Сэтгэл зүйн зөвлөгөө авах, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	“Итгэл, сэтгэл, хандлага” төрийн бус байгууллагын сэтгэл зүйч н.Ундрах “Бидний хандлага” сэдвээр сэтгэлзүйн сургалт зохион байгуулж, хэлтсийн алба хаагчид хамрагдсан. Цаашид байгууллага хамт олноороо бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө авч хамтарч ажиллахаар харилцан тохиролцсон.
5	Жендэр хариуцсан ажилтантай болох	Хэлтсийн даргын 2020 оны А/14 тушаалаар Жендэрийн ажлын хэсэг байгуулагдан 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
<b>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр</b>		
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн дагуу “Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, нийт ажилтнуудыг хамруулан шалгалт авч байна”, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалыг хэрэгжүүлж байгууллага бүр ХАБЭА-н сургалт явуулах эрх бүхий байгууллагаас сургалт авч ажилчдын мэдлэг хандлагыг дээшлүүлэх	Тус хэлтсийн алба хаагчид өдөрт дунджаар 100-150 иргэдтэй шууд харилцдаг ба халдварт өвчинд нэрвэгдэх хамгийн өндөр эрсдэлтэй байдаг. Тиймээс алба хаагчдын эрүүл ахуйн боловсролыг сайжруулах, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын олон нийттэй харилцах мэргэжилтэн эрүүл ахуйн сургалт зохион байгуулж хэлтсийн алба хаагчдыг хамруулсан. Аймгийн Эрүүл мэндийн газраас ХАБЭА-ын чиглэлээр сургалт авч халдварт өвчнөөс сэргийлэх талаар мэдлэг дээшлүүлсэн.
7	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх	Хэлтсийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалттай 2 албан хаагч ажиллаж байна.
8	Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулах	Хэлтсийн зүгээс өөрсдийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан байгууллагын алба хаагчдын цусан дахь сахарын хэмжээг тодорхойлох шинжилгээнд бүрэн хамруулсан. Мөн ажлын байран дахь дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулан өдөр бүрийн 10.30 цагаас 15 минутын дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн.

ТАЙЛАН БИЧСЭН:

УЛСЫН БҮРТГЭГЧ

Т.БУЛГАМАА

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТЭГШЖАРГАЛ

